Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний
өдрийн 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1		Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	**0,6**	**6**
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	**1**	**10**
3 (ҮХХ)	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	**0,5**	**5**
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	**0,5**	**5**
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	**0,5**	**4**
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	**0,4**	**5**
Хэсгийн оноо				**4**	**3,4**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	**1**	**10**
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	**1**	**10**
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	**1**	**10**
Хэсгийн оноо				**3**	**1**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	**1**	**10**
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	**1**	**10**
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	**1**	**10**
Хэсгийн оноо				**3**	**1**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				10	**9,4**	**95**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25 өдөр Мандалговь хот

НЭГ. Товч танилцуулга[1]

Аймгийн Засаг даргын тамгын газрын хамт олны саналаар сонгогдсон албан хаагчдыг байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн тушаалаар Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилон 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд 15 сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 агентлаг байгууллагын даргын тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 6 хэлтэс, 1 штаб, 1 төвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2025 онд төрийн албан хаагчтай холбоотой 1 гомдол Ёс зүйн дэд хороонд ирснийг хянан шалгаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дугаар заалтуудыг зөрчөөгүй гэж үзэн дүгнэлтийг гарган баталгаажуулж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцон үзэхэд ёс зүйн мэдлэг мэдээлэл дутмаг байдал, ажлын ачаалал, харилцан ойлголцол зэрэг хүчин зүйлээс шалтгаалах хандлага нэлээдгүй байгаа тул төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаануудыг үе шаттай зохион байгуулж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд АЗДТГ-ын төлөвлөгөө болон төрийн байгууллагууд Ёс зүйн дэд хорооны жилийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Энэ хүрээнд "Чадамжид суурилсан хүний нөөц" говийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулж, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын 27 төрийн албан хаагчид хамрагдаж, ажлын байранд зөөлөн ур чадварыг эзэмшүүлэх замаар байгууллагын соёл, ажилчдын хандлага, харилцааг дэмжих чиглэлээр мэдлэг олгосон. Зөвлөгөөний үр дүнд байгууллага бүр ажилчдадаа шаардлагатай ур чадвараа жил бүр тодорхойлж, зорилготойгоор хөгжүүлэх нь мэдлэг туршлагатай албан хаагчид, баг хамт олныг хадгалан үлдэж, ажлын бүтээмжийг дээшлүүлэн байгууллагадаа хувь нэмрээ оруулах боломжтой талаар мэдлэг мэдээллийг авсан.

Мөн Ёс зүй, манлайллыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан Оюунлаг Дундговь-Хүний хөгжил, Эр хүн сэдэвт чадавхжуулах сургалт, Зөв хандлага-эерэг нөлөө удирдлагын академийн сургалт, Чадамжид суурилсан хүний нөөц зэрэг нийт 5 сургалт, арга хэмжээг төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, харилцаа, ёс зүй, соён гэгээрүүлэх зорилгоор зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газрын хамт олон 7 хоног бүрийн баасан гаргийн 08.00 цагт хэлтсүүдийн мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулж, тус ажлын хүрээнд 6 хэлтсээс

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

мэдээлэл хийж, албан хаагчид товч танилцуулга, ажлын чиг үүрэг, өөрийн хариуцаж байгаа ажлын онцлогийн талаар танилцуулан, кофетой ярилцлага өрнүүлсэн нь нэгж хоорондын албан хаагчид бие биеийнхээ ажлын онцлогийг танин мэдэх, харилцан ойлголцож, хамтран ажиллахад дөхөм болсон арга хэмжээ болсон.





Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт тайлагнах чадавх дээшлүүлэх сургалтыг аймгийн Засаг даргын тамгын газраас Удирдлагын академийн сургуультай хамтарч, багш Ё.Батсүх “Орон нутагт бодлого боловсруулах, тайлагнах, үр дүнгийн шалгуур үзүүлэлт боловсруулах арга зүй” сэдвээр аймгийн Засаг даргын тамгын газрын болон харьяа агентлагуудын нийт 30 гаруй албан хаагчдад зохион байгуулсан.





Аймгийн Засаг даргын тамгын Ёс зүйн дэд хорооноос тухайн байгууллагад сүүлийн нэг жилийн хугацаанд шинээр орсон албан хаагчдыг хамруулан “Хуулиа дээдэлж, ёс зүйг эрхэмлэе” сэдвийн хүрээнд уулзалт зохион байгууллаа.

Тус уулзалтад оролцогчдод төрийн албан хаагчид хуулиар хязгаарлуулсан эрхээ хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллаж, ёс зүйг эрхэмлэн байгууллагын соёлыг хэвшүүлэх нь төрийн үйл ажиллагаа тасралтгүй, үр дүнтэй үргэлжлэх гол хүчин зүйл гэдгийг анхааруулан, шинээр батлагдсан байгууллагын дотоод журмын товч танилцуулга, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн товч танилцуулга болон төрийн албан хаагчдын зайлшгүй суралцах шаардлагатай /soft skill/ буюу зөөлөн ур чадварын талаар мэдээлэл өглөө.

Мөн төрийн албанд тогтвор суурьшилтай, олон жил ажиллаж байгаа албан хаагчдыг урилгаар оролцуулж, ажлын туршлагаас хуваалцахаас гадна залуу төрийн албан хаагчдын цаашид анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө өгч, ажлын байранд тулгамдаж буй хүндрэлтэй асуудлууд, алдаа онооны талаар харилцан санал солилцов.



Засаг даргын харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороод давхардсан тоогоор нийт 80 гаруй удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулснаас гадна төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар мэдээлэл, зөвлөмжийг албан хаагчдад хүргэн дотоод сүлжээ, мэдээллийн самбарт мэдээлж, ажлын байран дээр сурталчилж ажилласан зэрэг нь албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, эерэг өөрчлөлтийг хэвшүүлсэн арга хэмжээ болсон гэж үзэж байна.





Дундговь аймгийн хэмжээнд 8 сум, 15 байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээнд 500 орчим албан хаагчийг хамруулан зохион байгуулж, судалгаанд үндэслэн дундаж түвшинд хамааралтай 14 албан хаагч, өндөр эрсдэлтэй 8 албан хаагчид хариу арга хэмжээ авч, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулах, ажлын байранд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд “Шийдвэр гаргалтын алгоритм”, “Алдаа гарсан тохиолдолд хэрхэн засаж сайжруулахыг хамтдаа боддог, шийддэг соёлыг бий болгох” зэрэг соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулах бодлого, арга хэмжээг байгууллагын

үйл ажиллагаанд хэвшүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Хүндэлье энэрье” аянд 15 төрийн байгууллага нэгдэж, “Цай юу, Кофе юу?” ярилцлага, Сэтгэлийн үг-хайр илгээмж, Дараагийн хүндээ юу өгөх вэ? челленж, “Бусдад урмын үг хайрлах” гэх зэрэг олон талт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байна.
Дундговь аймагт үйл ажиллагаа явуулдаг хууль, хүчний байгууллагууд нэгдэн алба хаагчдын сэтгэл зүй, өөртөө итгэх итгэлийг дээшлүүлэх, гэр бүлийн уур амьсгал, харьцаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Эрүүл мэндийн байгууллага болон Улаанбаатар хотоос сэтгэл зүйчид, мөн ТББ-тай хамтран “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Сэтгэцийн эрүүл мэнд, түүнийг хамгаалах нь”, "Жендерт суурилсан гэр бүлийн харилцаа", “Өөдрөг сэтгэл зүй өнөөдрийн амжилт”, “Стрессийн хүчин зүйл түүнийг бууруулах арга зам болон Үр дүнд суурилсан тайлан бичих арга зүй”, “Уламжлалт анагаах ухаанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, “Тархины сэргэлт стратеги сэтгэлгээний нууц” зэрэг сэдвүүдээр 32 цагийн сургалтыг зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн арга хэмжээ болсон.




2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтнуудын хувьд үлгэр дуурайлал, шударга, тэгш харилцаа, ил тод, хариуцлагатай шийдвэр зэрэг нь албан хаагчдын ёс зүйн зөрчил, эрсдэлийг бууруулж, итгэл, хамтын ажиллагааг бэхжүүлэн, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд гол хүчин зүйл болох юм. Байгууллагын удирдлагуудын хувьд хууль дүрэм журмыг баримтлан ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд хүргүүлснээс гадна ёс зүйн хувьд хамт олныг манлайлан, харилцаа эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор зарим албан хаагчидтай биечлэн уулзаж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудлыг хувь хүнд нь анхааруулж, харилцан санал солилцож хэвшсэн.
2025 онд Олон улсын 7 удаагийн сургалт, зөвлөгөөнд аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 албан хаагч, Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 24 удаагийн төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 66 албан хаагчийг хамруулсан нь ажлын ур чадвар, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн арга хэмжээ болж байна.
Мөн хүний нөөцийн томилгоог холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахаас гадна шагнал урамшуулалд тодорхойлох асуудлыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн олонхын саналыг үндэслэн, албан хаагчийн ажлын үзүүлэлт, харилцаа хандлага, ур чадварыг зэрэг төрийн албан хаагчдад байх үзүүлэлтийг харгалзан шийдвэрлэж байна.

2.3. ЁС зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2025 онд 6 удаа хуралдаж дэд хорооны төлөвлөгөө хэлэлцэн батлах, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, албан хаагчдад чиглэсэн сургалт,

нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, төрийн албан хаагчийн гомдол хүлээн авч хянан хэлэлцэх, дүгнэлт гаргах, Ёс зүйн хорооноос зарласан аянд нэгдэж байгууллагадаа үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг асуудлуудыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэлээ. Аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг байгууллагын удирдлагын зүгээс тухай бүр дэмжин, гишүүдийн урамшууллыг олгож, Ёс зүйн дэд хороог хараат бус бие даасан байдлаар ажиллах, нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Ёс зүйн дэд хороо нь 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 11 заалтын хүрээнд боловсруулан баталж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд 3 удаагийн сургалт, 2 удаагийн уулзалт ярилцлага, нөлөөллийн ажлыг явуулсан. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын тамгын газарт 1 удаагийн гомдол ирсэн бөгөөд тухайн гомдлыг Ёс зүйн дэд хороо хянан шалгаж, ёс зүйн зөрчил гэж дүгнээгүй бөгөөд дэд хороо дүгнэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. Ёс зүйн дэд хороо нь гишүүдийн мэдээлэл, төлөвлөгөө, хэрэгжилт, ёс зүйн гомдлын бүртгэл мэдээллээ тухай бүр нэгдсэн мэдээллийн цахим системд бүртгэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний дүнд үндэслэн албан хаагчдад ёс зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, ажлын стресс, үл ойлголцлыг даван туулах, ёс зүйг мөрдөж, манлайлан ажиллаж буй нэгжийг урамшуулах зэргээр байгууллагын соёлыг дээшлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
- Албан хаагчдад ёс зүйн мэдлэг олгох сургалт, нөлөөллийн ажлуудыг төрийн байгууллагууд зохион байгуулах тоо өмнөх оноос өссөн.	1. Ажлын ачааллаас шалтгаалан төлөвлөгөөний дагуух үйл ажиллагаа хойшлох, цуцлагдах, нөлөөллийн ажлыг тогтмол явуулах боломж хомс
Санал: Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Лхагвабаатар/
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

ЁС зүйн дэд хорооны дарга
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
ТЗУХ-ийн мэргэжилтэн /Г.Оюунтунгалаг/
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 25

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Н.ЭРДЭНЭ-ОЧИР

2025 оны ... дүгээр сарын .....

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 04 сарын 04 өдөр

Мандалговь

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	Ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах, ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх хуралдааныг тухай бүрд зохион байгуулах	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны дарга Н.Эрдэнэ-Очир Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Г.Оюунтунгалаг	Тухай бүр хуралдаан зохион байгуулсан байна.
2	Ёс зүйн зөрчил мэдээллийг бүртгэлд авч, ёс зүйн хорооны гишүүдэд хуваарилан, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны дарга Н.Эрдэнэ-Очир Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Г.Оюунтунгалаг	Ирсэн гомдол, мэдээллийг журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.
3	Албан хаагчдад ёс зүйн сургалт зохион байгуулах	4 дүгээр сард	Ёс зүйн дэд хорооны гишүүн Д.Дааримаа	Төрийн албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголт, мэдлэгтэй болно.
4	Байгууллагын доторх хэлтэс, албадтай хамтран сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хороо	Ажлын байранд суралцах, хөгжих боломж бүрдэнэ.
5	Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлэх зорилгоор сургалт, сарын аян зохион байгуулах	5 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны гишүүн Г.Энхтайван	Ёс зүйн өндөр төлөвшилтэй байгууллага болно.
6	Шинээр орсон албан хаагчидтай уулзах “Ахмадаас суралцъя” уулзалт зохион байгуулах	5 дугаар сард, Тухай бүр	Ёс зүйн дэд хороо	Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалт, нөлөөллийн ажилд хамруулж хэвшсэн байна.

7	Албан хаагчдын ёс зүй, манлайллын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	9-11 дүгээр сард	Ёс зүйн дэд хороо	Албан хаагчдын ёс зүй, манлайлал дээшилж, байгууллагын соёл тогтоно.
8	Ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээлэл, хянан шалгах ажлын явц, дүгнэлт болон шийдвэрийн бүртгэлийг тухай бүр ёс зүйн цахим дэд системд бүртгэх	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Г.Оюунтунгалаг	Цахимд тухай бүр бүтгэгдсэн байна.
9	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг дэд системд бүртгэж, биелэлтийг тухай бүр шинэчлэн оруулах	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Г.Оюунтунгалаг	Төлөвлөгөөг системд бүртгэж, биелэлтийг тухай бүр шинэчлэн оруулсан байна.
10	Ёс зүйн хорооны гишүүдийн урамшууллын асуудлыг удирдлагуудад танилцуулан холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны дарга Н.Эрдэнэ-Очир	Ёс зүйн хорооны гишүүдийн ажиллах баталгаа хангагдана.
11	Төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, арга хэмжээнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх	4-12 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны дарга Н.Эрдэнэ-Очир	Ёс зүйн хорооны үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй явагдана.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.ОЮУНТУНГАЛАГ